



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 23 өдөр

Дугаар А/154

Мөрөн

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй хоёр долгионы хэмжлийн багажны засварын үнэ болох 3249840 төгрөгийг захиалагчийн хяналтын зардлаас зарцуулсугай.

2. Хоёр долгионы хэмжлийн багажны засварыг чанартай гүйцэтгүүлж, багажыг хэвийн үйл ажиллагаанд оруулж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Н.Бямбадорж/-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Х.Ган-Очир/, Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга /Г.Сувд/ нарт даалгасугай.

ДАРГА

Л.ГАНБОЛД